

“ХАЛДВАРТ ӨВЧИН СУДЛАЛЫН МОНГОЛЫН СЭТГҮҮЛ”-Д НИЙТЛҮҮЛЭХЭЭР ИРҮҮЛЖ БУЙ МАТЕРИАЛД ТАВИГДАХ ШААРДЛАГА

1. Сэтгүүлд нийтлүүлэхээр ирүүлж буй материал нь а) эрдэм шинжилгээний өгүүлэл, б) лекц, тойм, зөвлөгөө, в) товч мэдээ, г) эпоним, д) бодрол бясалгал, е) бусад гэсэн хэлбэртэй байна. Нийтлүүлэхээр ирүүлсэн бүх материалын гарчигийг англиар давхар бичсэн байна.
2. Нийтлүүлэх бүх материалыг зөвхөн цахим шуудангаар доорхи хаягуудын аль нэгээр хүлээн авна. Үүнд: сэтгүүлийн эрхэлсэн нарийн бичгийн дарга, анагаах ухааны доктор Д.Наранзул: ndambaa2020@gmail.com, ndambaa@yahoo.com, нарийн бичгийн дарга, анагаах ухааны доктор А.Бурмаа: aburma69@gmail.com, Холбоо барих утас: Д.Наранзул 99072366; А.Бурмаа 99085415
3. Эрдэм шинжилгээний өгүүлэл, лекц, тойм, зөвлөгөөнөөс бусад нийтлүүлэх материалд тусгай шаардлага тавигдахгүй бөгөөд харин ирүүлсэн материалыг товчлох, 10-аас олон хуудас материалыг хэд хэдэн дугаарт таслан хэвлэх эрхийг редакцийн зөвлөл эдэлнэ.
4. Эрдэм шинжилгээний өгүүллийг (цаашид өгүүлэл гэх) өөрсдийн хийсэн судалгааны ажлын үр дүнд үндэслэн бичих бөгөөд нийтлүүлэхийг зөвшөөрсөн эрдэм шинжилгээний удирдагчийн зөвшөөрөл буюу байгууллагын захирал, эрхлэгчийн албан бичигтэйгээр ирүүлнэ.
5. Өгүүллийг А4 хуудасны нэг талд 31 мөрөөр Arial буюу New Times Roman шрифтээр 12-ын үсгээр бичнэ.
6. Өгүүлэл нь хүснэгт, зураг, ном зүй, товчлолыг оролцуулан 10 хуудаснаас хэтрэхгүй хэмжээтэй байна.
7. Өгүүллийн эхэнд бүтээлийн нэр, зохиогчийн нэр, зохиогчийн харъяалагдах албан байгууллагын нэр, гол судлаачийн e-мэйл хаяг, түлхүүр үгсийг монгол, англиар доорхи жишгээр бичнэ:

NEISSERIA GONORRHOEAE-ИЙН ЭМИЙН ТЭСВЭРЖИЛТИЙГ ТОДОРХОЙЛОХ АРГУУДЫГ ХАРЬЦУУЛАН СУДАЛСАН ДҮН

Ц.Уранцэцэг^{1, 2}, Д. Нармандах¹, Т. Одгэрэл¹, Э. Цацрал¹, М. Алтанхүү¹, Т.Хосбаяр²,
С.Цогтсайхан²

¹Халдварт Өвчин Судлалын Үндэсний Төвийн Нэгдсэн Лабораторийн Алба,

²Эрүүл Мэндийн Шинжлэх Ухааны Их Сургуулийн Био-Анагаахын сургууль

e-мэйл: urantsetsegt@gmail.com

Түлхүүр үгс: антибиотик тэсвэржилт, *N.gonorrhoeae*

Key words: antibiotic resistance, *N.gonorrhoeae* гэх мэтээр бичнэ.

8. Өгүүлэл нь удиртгал (5%), материал, арга зүй (10%), үр дүн (60%), хэлцэмж, дүгнэлт (25%) гэсэн жишигтэй хэсгүүдээс бүрдэнэ. Өгүүлэлд ном зүйн жагсаалт хавсаргана.
9. Анагаахын нэр томъёог П.Нямдаваа нарын “Анагаах ухааны Монгол нэр томъёоны англи, герман, латин, орос, франц хэлээр хадмал орчуулгатай товч тайлбар толь”-д байгаагаар буюу уг тольд байхгүй үгийг уг тольд баримталсан зарчмын дагуу бичнэ.
10. Бичил биетэний нэрийг латинаар *бичмэл шрифтом (italic)* ашиглан бичнэ.
11. Өгүүлэлийн бичлэг нь зөв, бичгийн дүрмийг баримталсан, алдааг сайтар нягталсан, математик, химийн томъёог шалгасан, алдаа мадаггүй байна.

12. Зураг, график аль болох цөөн, зөв оновчтой сонгосон, үр дүнгийн текст хэсгийг шууд давтаагүй, босоо, хэвтээ тэнхлэгийн утга, хэмжих нэгжийг зөв томъёолж бичсэн байна. Фото зураг тод, болж өгвөл хар-цагаан өнгөтэй байна. Фото зургийн орох байрлалд текст дотор тайлбарыг монгол, англиар давхар бичээд, эх зургийг тусад нь JPEG файлаар хавсаргана. Зургийн дугаар, нэр зургийн доор бичигдэнэ.

13. Хүснэгт нь сайн шахаж хийсэн, хүснэгтийн бүх тоон утга нь үр дүнд бичсэн агуулгатай бүрэн тохирсон, хүснэгтийн нэр товч, оновчтой байна. Хүснэгтийн дугаар нь хүснэгтийн баруун дээд өнцөгт, нэр нь хүснэгтийн дээд талд бичигдэнэ. Хүснэгтэд орсон текстийг англи хэлээр дорхи маягаар давхар бичсэн байна.

Хүснэгт 1

Table 1

N.gonorrhoeae-ийн 57 омгийн эмийн мэдрэг чанарыг 3 аргаар тодорхойлж нийцлийг харьцуулсан дүн

Results of antibiotic resistance testing with 3 methods for 57 strains of *N.gonorrhoeae*

Антибиотикийн нэр (Antibiotics tested)	Тодорхойлсон арга (Methods of testing)	Тэсвэртэй (Resistant)	Дунд мэдрэг (Intermediate)	Мэдрэг (Sensitive)	Каппа (κ)
Пенициллин Penicillin	КБ	19 (33.3%)	37 (64.9%)	1 (1.8%)	0.796
	ТДМ	19 (33.3%)	35 (61.4%)	3 (5.3%)	0.450
	Е тест	18 (31.6%)	33 (57.9%)	6 (10.5%)	

14. Материал, аргазүйн хэсгийн төгсгөлд био-анагаахын ёс зүйн асуудлыг судалгаандаа хэрхэн зохицуулсан, ёс зүйн хорооны зөвшөөрөл авсан тухай, түүнийг хэрхэн мөрдөж ажилласан тухай товч тусгасан байна.

15. Өгүүлэлд ном зүйгээс ишлэл оруулахдаа дөрвөлжин хаалтанд номзүйн жагсаалт дахь дугаарыг тавина.

16. Ном зүйн жагсаалтыг тусгай хуудас дээр, эхний зохиогчийн нэрний эхний үсгийн цагаан толгойн дарааллаар (эхлээд өөрийн орны, дараа нь гадаадын зохиогчтой бүтээлийг) эсвэл, бүтээлд оруулсан дарааллаар олон улсад тавигддаг шаардлагын дагуу жагсааж, дугаарлан бичнэ. Ингэхдээ: зохиогчийн нэр, нийтлэгдсэн он (хаалтанд, тодоор, доогуур нь зурсан), өгүүллийн нэр, сэтгүүлийн нэр (бичмэл шрифтээр доогуур нь зурсан; гадаад сэтгүүлийн нэрийг бол олон улсад тогтсон журмын дагуу товчилж бичиж болно), дугаар, хуудас гэсэн дарааллаар бичнэ. Гурваас олон зохиогчтой ишлэлийн эхний 3 зохиогчийг бичээд “ба бусад” гэж товчилж болно:

Сэтгүүлээс өгүүлэл иш татах жишээ:

Нямдаваа, П., Энхсайхан, Д., Майцэцэг, Ч. ба бусад(**2010**): Монгол улсад ялгасан томуугийн А(H1N1)2009 цартахлын вирүсийн молекул генетикийн төрх, Халдварт өвчин судлалын Монголын сэтгүүл, 6(49): 7-12;

Bolton, KJ, McCaw, JM, Moss, R. et al., (**2013**): Likely effectiveness of pharmaceutical and non-pharmaceutical interventions for mitigating influenza virus transmission in Mongolia, Bull.WHO, 90(): 264-271;

Ном, нэг сэдэвт зохиол, эмхтгэлээс иш татах жишээ:

Нямдаваа, П. (**1986**): Вирүс судлалын үндэс, УХГ, Улаанбаатар, 226 х.;

Lavanchy, D., Алтанхүү, М. (**2010**): Хепатит, вирүст, “Халдварт өвчний хяналтын лавлах”, 18 дахь хэвлэлийн монгол орчуулга, номонд, Улаанбаатар, х.565-592;

Murphy, FA, (**1985**): Virus Taxonomy, In: Virology, Editor-in-Chief B.N.Fields, Raven Press, pp.7-26;

Хэвлэгдсэн илтгэлийн товчлолыг иш татах жишээ:

Нямдаваа, П., Наранзул, Д., Зулхүү, Г. ба бусад (**2003**): Монгол улсад импортлогдсон АЦХаХ-ын тохиолдлыг оношлож, тархалтыг таслан зогсоосон нь, *Биологи, анагаах ухааны түлгэмдсэн асуудлууд (Монголын шинжлэх ухааны ажилтны өдөрт зориулсан эрдэм шинжилгээний бага хурал, 2003-11-24)*, Улаанбаатар, эмхтгэлд, х.5-7;

Burmaa, A., Darmaa, B., Urtnasan, Ch. et al (**2013**): The second and third waves of A(H1N1)pdm09 virus attacks in Mongolia, In: *Options for Control of Influenza, Cape Town, South Africa, 5-10 September, 2013, Abstracts*, pp.42-43;

Он-лайн материалыг иш татах жишээ:

Нямдаваа, П. Томуугийн А(Н7N9) вирүст халдварын тухай мэдээ: 31/13, http://www.flu.mn/mgl/index.php?option=com_content&task=view&id=1136&Itemid=49, accessed on Dec.11, 2013;

Xinhua: China confirms 132 H7N9 cases, 43 deaths <http://english.peopledaily.com.cn/90882/8320775.html> accessed on July 10, 2013;

17. Өгүүлэлд 300 үгэнд багтсан англи товчлол хийх бөгөөд түүнд өгүүллийн үндсэн агуулгыг товчлон бичсэн байна. Англи товчлол нь Introduction, Goal, Materials and Methods, Result(s), and Conclusion(s) гэсэн бүтэцтэй байна. Товчлолын эхэнд өгүүллийн нэр, зохиогч, байгууллагын нэрийг бүтнээр нь англиар бичнэ.

18. Хэвлэлийн тоймыг 50-аас доошгүй эх сурвалж ашиглан бичсэн байх ба тавигдах шаардлага нь энэ зааврын 9-17-д бичсэнтэй ижил байна.

19. Лекц, зөвлөгөөний эх бичвэрт хэвлэлийн тоймтой адил шаардлага тавигдах боловч, ашигласан хэвлэл нь цөөн байж болно.

20. Өгүүлэл, лекц, тойм, зөвлөгөөний бичвэрийн сүүлийн хуудсан дээр зохиогчид бүгд нэрээ бичиж, ард нь гарын үсэг зурж, эргэж холбоо барих зохиогчийн утасны дугаар, мэйл хаягийг бичсэн байна.

21. Өгүүлэл, лекц, тойм, зөвлөгөөнийг уг сэдвээр мэргэшсэн сэтгүүлийн зөвлөлийн гишүүнээр уншуулж санал авах бөгөөд сэтгүүлийн зөвлөлийн гишүүн уг эх бичвэр сэтгүүлд нийтлүүлэх материалын энэ шаардлагыг хангаж чадаж байгаа эсэх, агуулга нь нийтлэлийн чанарын шаардлага биелүүлэх эсэхийг нухацтай судлаж, нийтлэх эсэх саналаа сэтгүүлийн уг дугаарыг эрхлэн гаргаж буй сэтгүүлийн зөвлөлийн гишүүнд болон эргэж холбоо барих зохиогчид өгнө. Сэтгүүлийн зөвлөлийн гишүүн зохиогчидтой шууд холбоо барин асууж, тодруулж болно.

22. Сэтгүүлийн редакци нь өгүүллийг засах эрхтэй бөгөөд зохиогчтой тохиролцсоны үндсэн дээр уг материалыг товчилсон байдлаар нийтэлж болно.

23. Тус сэтгүүлд нийтлүүлэхээр ирүүлж буй бүх материал өмнө нь өөр хэвлэлд нийтлэгдээгүй байх ёстой бөгөөд энэ талаар бусад сэтгүүл, сонины газраас гомдол, маргаан гарвал, хариуцлагыг зохиогчид хүлээнэ.

24. Дээр дурдсан шаардлагыг хангаагүй материалыг зохиогчидод нь буцаана.

25. Сэтгүүлд нийтлэгдэж байгаа өгүүллийн эхийг буцаахгүй.

26. Сэтгүүлд ирүүлсэн хугацааг материал нийтлэгдэхэд бэлэн болсон эцсийн хувилбарыг ирүүлсэн хугацаагаар тооцно.

27. Сэтгүүлд нийтлүүлэхээр ирүүлсэн материалыг ирүүлсэн дараалалыг нь баримтлан нийтэлнэ. Гэхдээ сэтгүүлийн дугаарын сэдэвт тохируулан хойшлуулах эрхийг редакци эдлэнэ.

28. Ирүүлсэн материалыг дугаар харгалзахгүй хурдан хэвлүүлэх хүсэлтэй бол түүнийг сурталчилгааны материалтай адил тооцож, нийтлэгдсэн нэг нүүрийг 150 000 төгрөгийн төлбөртэйгээр хэвлүүлж болно.

29. Бүх төрлийн сурталчилгааг хэвлэмэл нэг нүүрийг 150 000 төгрөгөөр тооцож төлбөр авна.

30. Сэтгүүлд эрдэм шинжилгээний өгүүлэл нийтлүүлэх төлбөрийг хийхдээ а4 хэмжээний нэг нүүр бүрийг 5000 төгрөгөөр тооцож Хаан банк дахь “Халдварт өвчин судлалын Монголын сэтгүүл”-ийн 5753063570 тоот дансанд тушаасан баримтыг ирүүлнэ. Албан байгууллагууд сэтгүүлийн дансанд төлбөр хийх бол 1053027 регистрийн дугаарыг ашиглана.

Сэтгүүлийн редакцийн зөвлөл